

ТАНИЛЦУУЛГА

*Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл (“К”)-ийг тогтоох тухай
Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2023.11.29

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 2014, 2017, 2019, 2021 онуудад баталсан.

Хүснэгт 1

Хүйс	Он									
	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Эмэгтэй	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил	22 жил	22 жил
Эрэгтэй	-	-	-	-	-	15 жил 6 сар	15 жил 6 сар	15 жил	15 жил	15 жил

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу өндөр насны тэтгэврийн хэмжээг нэрийн дансны аргаар бодохдоо тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг ашиглахаар баталсан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ний өдрийг 20 дугаар тогтоолын 3 дугаар заалтад “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй” гэж заасан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3-д заасны дагуу тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2024 онд эмэгтэй даатгуулагч 22 жил, эрэгтэй даатгуулагч 15 жил байх тогтоолын төсөл боловсруулсан.

Мөн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ний өдрийг 20 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2023 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй” гэж өөрчлөн найруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны ... сарын өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй.

2. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 20 дугаар тогтоолын 1 дэх заалтыг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-ийг 2022-2023 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоож мөрдсүгэй” гэж өөрчилсүгэй.

3. Энэ тогтоолоор баталсан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу нэрийн дансны аргаар өндөр насны тэтгэвэр бодоход баримталж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба (Г.Банзрагч) -нд үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гарын үсэг